



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

“Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, 34,400,000.00 (гучин дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 32,920,022.19 (гучин хоёр сая есөн зуун хорин мянга хорин хоёр төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ерэн-Өлзий, “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал П.Санлигрэнчин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

122001634
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2026 оны 07 дугаар сарын 08 -ны өдрийн
388 дугаар тогтоолын хавсралт

"ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуриятлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2024 оны 491 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөг)
1	Истана /Istana Ssangyong/, улсын дугаар 00-52 ХӨА, микробус, арлын дугаар КРДАВ5Е81ХР083582	1999	ш	1	13,000,000.00	13,000,000.00		-	1,500,000.00	750,000.00
2	Зил-130, улсын дугаар 23-72 ХӨА, ачааны, арлын дугаар 2842480	1989	ш	1	5,300,000.00	5,300,000.00		-	2,000,000.00	1,000,000.00
3	Мицубуши страда /Mitsubishi Strada/, улсын дугаар 03-43 ХӨВ, суудлын, арлын дугаар К741000515	1998	ш	1	16,100,000.00	16,100,000.00	14,620,022.19	1,479,977.81	2,000,000.00	1,000,000.00
Нийт дүн						34,400,000.00	32,920,022.19	1,479,977.81	5,500,000.00	2,750,000.00
						(гучин дөрвөн сая дөрвөн зуун мянга)	(гучин хоёр сая есөн зуун хорин мянга хорин хоёр төгрөг арван есөн мөнгө)	(нэг сая дөрвөн зуун далан есөн мянга есөн зуун далан долоон төгрөг наян нэгэн мөнгө)	(таван сая таван зуу)	(хоёр сая долоон зуун тавин мянга)